



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн 2023 оны дугаар
сарын-ны өдрийн
дугаар албан бичгийн хавсралт

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1 Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;

Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд байршуулсан тв шторк, ирүүлсэн зөвлөмж, зурагт хуудсыг компанийн албан ёсны цахим хуудас болох <https://transco.mn/news/> сайт болон фэйсбүүк хуудаст тухай бүр байршуулж түгээж ажилласан. Авлигын эсрэг сурталчилгааны материалыг компанийн хэлтэс, салбар, албанд тус бүр хүргүүлж нийт 150 гаруй материалыг тараасан. Мөн албан конторуудын мэдээллийн самбарт зурагт хуудсуудыг байршуулан олон нийт болон компанийн ажилтнуудийг мэдээлэлтэй танилцах боломжоор хангаж ажилласан.



1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;

☞☞☞ Авлигын эсрэг "НЭГДЬЕ" соён гэгээрүүлэх аян ✓✓✓ Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх 5Ш ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалгад Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь нэгдсэн. Салбар нэгжүүдэд Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Байгууллагын хаалтай цахим группт авилгын эсрэг сэрэмжлүүлэх санамжуудыг тогтмол оруулсан. Мөн ажлын байранд мэдээллийн самбарт хэвлэмэл хуудас бүхий санамжуудыг байршуулж ажилтнууддаа авилгын талаарх ойлголт болон авилгын хор нөлөө түүнээс ангид байх талаар мэдээ мэдээллээр хангаж ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх "шүүр" ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/84 дугаар тушаалын хүрээнд компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан дотоод хяналт шалгалтыг зохион байгууллаа. Энэхүү хяналт шалгалтаар Албан тушаалын тодорхойлолтод нийцээгүй, ХАСУМ хянуулаагүй, тусгай шалгалт өгөөгүй, Хууль, компанийн дүрмийн холбогдох заалт зөрчин томилогдсон талаар дотоод хяналт шалгалтыг явуулсан. Нийт 1240 ажилтан хамрагдсанаас 10 зөрчил илэрснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн.

1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;

Авлигын эсрэг хамтдаа" мэдээллийн самбарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигын эсрэг ерөнхий төлөвлөгөө бусад холбогдох мэдээ, мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчлэн ажилтнуудад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн сурталчилгааны материалыг компани болон салбаруудын оффис хүлээлгийн өрөө, мэдээллийн самбар, цаг бүртгэлийн төхөөрөмжийн хажууд тогтмол байршуулан ажиллаж байна.



2. Авлигын эсрэг болон гэм хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах

2.1 Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр 2023 онд шинээр томилогдсон албан тушаалтнууд болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтнуудад сургалтуудыг явуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад Zoom-ээр тухай бүр хамруулсан. Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Эрх бүхий албан тушаалтнуудад АТГ-аас явуулсан сургалтад тогтмол хамрагдсан.



2.2 Хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтын хүрээнд хэлтэс, салбаруудад “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хүүхдийн хүмүүжлийн эерэг арга, Цахим гэмт хэрэг, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлж байгаа хууль тогтоомжууд зэрэг сэдвүүдийн хүрээнд Багахангай дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Д.Аянагул, Орхон аймгийн прокурорын газрын прокурор Анх-Ирээдүй, Дархан-уул аймаг дахь цагдаагийн газар, БГД-ийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийн цагдаагийн хошууч Г.Өнөржаргал, ЦЕГ-ын Зөрчлийн хэрэг бүртгэх газрын урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил хариуцсан ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч Н.Ганбаяр, компанийн хуулийн зөвлөх Г.Алтангэрэл нар тус тус заасан. Сургалтад танхимаар 240 ажилтан, цахимаар 430 ажилтан хамрагдсан.



3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох;

/Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх/

Гэрээнд оролцогч талууд нь ажил үүргээ гүйцэтгэснийхээ төлөө ямар нэг бэлэг, шан харамжийн зүйл болон бусад хууль бус урамшуулал, хангамж авах, өгөхийг хориглосон зохицуулалтыг гэрээнүүдэд тусгаж, мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүсэн тухай мэдэгдлийг нийт 84 тендерийн үнэлгээний хорооны гишүүд болон тухайн гэрээнд гарын үсэг зурсан албан тушаалтнуудаас гаргуулан авсан. Компанийн хэмжээнд байгуулагдаж байгаа гэрээнүүдэд гэрээ цуцалсан тохиолдолд буруутай тал нь хариуцлага хүлээх иргэний хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах тухай зохицуулалтыг тусгасан. Мөн гэрээ дуусгавар болсон тохиолдолд компанийн “Гэрээ бүртгэх, биелэлтэд хяналт тавих, дүгнэх, архивлах журам”-ын хүрээнд гүйцэтгэлийн актыг үндэслэн гэрээ дүгнэсэн актыг үйлдэж ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд

4. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Эрчим хүчний сайд, Эрчим хүчний зохицуулах хороо, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болсон эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.

Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг хууль тогтоомж, дээд байгууллагаас гаргасан дүрэм, журамд нийцүүлэх талаар үе шаттайгаар ажлууд хийгдэж байна. Тухайлбал хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан компанийн хөдөлмөрийн дотоод журам, цалин тогтоох журам, ажлын цаг ашиглалтын журам, Салбаруудын чиг үүрэг, эрх үүргийг ижил түвшинд байлгах, санхүүгийн эрх хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн салбарын дүрмийг тус тус шинэчлэн баталсан. Мөн Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт/тарифт хэлэлцээрийн дагуу компанийн хамтын гэрээг шинэчлэн байгуулсан.

5. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах

5.1 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх;


Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн дүгнэлтийг 05 дугаар сарын 01-ний дотор, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх (өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор шилэн дансны мэдээлэлд байршуулах ажил хийгдэж байна. Шилэн дансны мэдээллийг компанийн гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/241 тоот тушаалаар томилогдсон ажилтнууд хариуцан шилэн дансны тухай хуулийн 7.1.1 дэх заалтад заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь ил тодоор тайлагнаж, шилэн дансны сайтад байршуулж, компанийн дотоод аудитор хяналт тавьж ажиллаж байна.

5.2 Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д ажилтнууд болон иргэд, байгууллагаас 2023 хагас жилийн байдлаар нийт 827 өргөдөл бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлснийг бүртгэлжүүлэн тухай бүр шийдвэрлэж ажилласан. Компанийн хэмжээнд тайлант онд нийт 1698 өргөдөл ирснээс шийдвэрлэсэн 1682, шийдвэрлэх шатанд хүлээгдэж байгаа 16 өргөдөл байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг мэдээг 14 хоног дутам болдог компанийн өргөтгөсөн шуурхай зөвлөгөөнд мэдээлэн ажиллаж байна.

5.3 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах;

Сул орон тооны зарыг компанийн вэб сайт, пейж хуудастаа байршуулж, өдөр тутмын сонинд нийтлүүлэн, ажилд орох хүсэлтэй ажил горилогчдын анкетыг хүлээн авч ажилласан. Энэ оны 12 сарын байдлаар давхардсан тоогоор 50 орчим ажлын байрны зарыг олон нийтэд хүргэсэн байна. Анкет материал ирүүлсэн хүмүүсийн материалуудаас сонгон шалгаруулалт хийж, мэргэжлийн шалгалт авч ажилд авсан.



The National Power Transmission Grid (NPTG) State-Owned Stock Company

Vacancy Announcement

In the framework of the German-Mongolian Financial Cooperation, the Government of Mongolia has received a loan from the Government of the Federal Republic of Germany through the KfW bank, toward the cost of the Energy Efficiency in the Central Transmission and Distribution Network Project. The National Power Transmission Grid (NPTG) State-Owned Stock Company of Mongolia, the Project Executing Agency, is now recruiting qualified specialists for the Project Implementation Unit (PIU).

1. Project Coordinator (1)
Contract Period: 12-24 person-months

Project Coordinator will report to the Project Management Unit (PMU) and will be responsible for coordination and completion of project on time within budget and within scope. Specific responsibilities are to plan, direct, coordinate, and lead project activities to ensure that goals, objectives, and all elements within the planned time frame.

Required qualifications:

- The Project Coordinator should have:
- University degree in Energy, Electrical engineering or a discipline relevant to the

- Preference to have Bachelor and Master's degree
- Good and confident communication, leader and motivator
- Capable written and spoken English preferred
- The candidate must have at least 5 years' work experience in a state and international organization

Required Documents: (All documents should be in English)

- CV with cover letter
- Civil servant application, (only in Mongolian)
- Copies of relevant diplomas and certificates
- Photocopy of citizenship ID
- Evidence of Language proficiency
- Recommendation letter from previous employer

Application Deadline: 4:00 PM, June 26, 2023
Application submission: b.solongo@nptg.mn

Room No. 407

Solongo B.
Human Resource expert, Management Department
National Power Transmission Grid (NPTG)
State-Owned Stock Company
Phone: 976-99196011

Chingis Avenue 45, Khan-Uul district, 3rd

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС